



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/364

Номгон

Аймгийн Засаг даргын Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээ дүгнэх үнэлгээний багийг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/122 дугаар тушаалаар батлагдсан "Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах гэрээг дүгнэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үнэлгээний багийн ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Эрүүл мэндийн газрын Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Статистик, мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны Баянхонгор аймаг дахь салбарын дарга

Харьяаллын иргэний төлөөлөл

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

2. Үнэлгээний баг нь Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээний биелэлтийн үнэлгээг хагас жилээр (7 дугаар сарын 03)-ны дотор, жилийн эцсээр дараа жилийн (1 дүгээр сарын 03)-ны дотор багтаан зохион байгуулсугай.


624010878

3. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэх ажлыг товлосон хугацаанд чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Үнэлгээний багийн ахлагч (В.Наранчимэг)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээ дүгнэх ажлын хэсэг томилох тухай" аймгийн Засаг даргын 2023 оны А/377 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН